



ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР



Улирал тутам

Дугаар №2

# ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот  
2012 он



Редактор: Ш.Энхбат, Анагаахын шинжлэх ухааны доктор

Хянасан: С.Ариунтуяа, НЭМ-ийн магистр

Эмхтгэсэн: Х.Нарантуяа, Удирдахуйн ухааны магистр  
С.Даваажаргал /ЭМСХ-мэргэжилтэн/  
Т. Энхжаргал /ЭМСХ-мэргэжилтэн/

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Уранчимэг  
Д.Алтанцэцэг

**Энэхүү эмхтгэлийн талаархи саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.  
Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг-Эрүүл Мэндийн Газар**

Шуудангийн хаяг: С.Зоригийн гудамж  
Улаанбаатар -210648  
Факс: 976-11-320633  
Утас: 70111485, 325540  
Э-шуудан: admin@doh.gov.mn  
www.doh.gov.mn

## Товчилсон нэр томъёоны тайлбар

|     |                       |
|-----|-----------------------|
| АР  | Архангай              |
| БӨ  | Баян-Өлгий            |
| БХ  | Баянхонгор            |
| БУ  | Булган                |
| ГА  | Говь-Алтай            |
| ГС  | Говьсүмбэр            |
| ДА  | Дархан-Уул            |
| ДГ  | Дорноговь             |
| ДО  | Дорнод                |
| ДУ  | Дундговь              |
| ЗА  | Завхан                |
| ОР  | Орхон                 |
| ӨВ  | Өвөрхангай            |
| ӨМ  | Өмнөговь              |
| СҮ  | Сүхбаатар             |
| СЭ  | Сэлэнгэ               |
| ТӨ  | Төв                   |
| УВ  | Увс                   |
| ХО  | Ховд                  |
| ХӨ  | Хөвсгөл               |
| ХЭ  | Хэнтий                |
| АД  | Аймгийн дүн           |
| УБ  | Улаанбаатар           |
| УД  | Улсын дүн             |
| ЧД  | Чингэлтэй дүүрэг      |
| БГД | Баянгол дүүрэг        |
| ХУД | Хан-Уул дүүрэг        |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| СБД | Сүхбаатар дүүрэг      |
| БЗД | Баянзүрх дүүрэг       |
| НАД | Налайх дүүрэг         |
| БНД | Багануур дүүрэг       |

## Өмнөх үг

Эрүүл мэндийн салбар 2012 оныг “ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ЖИЛ” гэсэн уриатайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. Түүнчлэн “Мянганы хөгжлийн эрүүл мэндийн зорилтууд” болон “Эх хүүхдийн эрүүл мэндийн стратеги”, “Эрүүл хүүхэд аян”, Халдварт бус өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зэрэг олон стратеги нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр төслүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулж эхлээд байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Эрүүл мэндийн газрын статистикийн хэлтсээс 2012 оны эхний хагас жилийн албан ёсны статистик мэдээ, мэдээлэлд тулгуурлан “Эрүүл мэндийн статистикийн улирлын мэдээлэл”-ийг эмхэтгэл хэлбэрээр хэвлүүлж та бүхэнд хүргүүлж байна.

Энэхүү эмхэтгэл нь хүн амын өвчлөл болон нас баралтын тэргүүлэх шалтгаануудыг бүс, аймаг, хүйс, насны бүлэг, эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлал болон нийслэлийн дүүргүүдээр харьцуулан улиралчилсан байдлаар гаргаж байна. Өвчлөлийн тоон болон харьцуулсан мэдээллийг нийслэл, аймгаар харуулсан нь өвчний хөдлөл зүйг улирлаар дүгнэх, хянах боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд бүх түвшний бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, мэдээлэл хэрэглэгчид ашиглах боломжтой юм. Мөн 2-р улирлын мэдээлэлд лабораторийн үйл ажиллагааны үзүүлэлтийг аймаг, нийслэл, эмнэлэг, дүүргүүдээр гаргасан нь шинэлэг болж Та бүхний сонорт хүргэж байгаагаараа онцлог юм.

2012 оны эхний хагас жилийн байдлаар 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 49.8, 1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдэл 16.3, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 19.7 байгаа нь өмнөх онуудын мөн үеийн түвшингээс буурсан үзүүлэлттэй байна.

Энэхүү эмхэтгэлийг хэвлүүлэн, мэдээлэл хэрэглэгчдийн хүртээл болгоход санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Глобаль сангийн ДОХ, Сүрьеэтэй тэмцэх төслийн хамт олонд талархал илэрхийлье. Эрүүл мэндийн бодлого боловсруулагчид, бүх түвшний шийдвэр гаргагчид эмч, эмнэлгийн ажилтан болон мэдээлэл хэрэглэгч нийт хүмүүст нотолгоонд тулгуурласан оновчтой шийдвэр гаргахад бидний энэхүү эмхэтгэл тус болно гэдэгт бүрэн итгэлтэй байна.

**ДАРГА**

**Ш.ЭНХБАТ**

## **ГАРЧИГ**

**БҮЛЭГ I. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЗОРИЛТУУД**

**БҮЛЭГ II. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД**

**БҮЛЭГ III. АМБУЛАТОРИ, СТАЦИОНАРЫН ТУСЛАМЖ**

**ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**


**БҮЛЭГ IV. ХАЛДВАРТ БУС ӨВЧИН**

**БҮЛЭГ V. ХАЛДВАРТ ӨВЧИН**

**БҮЛЭГ VI. ХҮН АМЫН НАС БАРАЛТ**

**БҮЛЭГ VII. ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

## БҮЛЭГ I. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЗОРИЛТУУД



## БҮЛЭГ I. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЗОРИЛТУУД

2012 онд Монгол улсын эдийн засаг нийгмийн хөгжлийн 2012-2016 оны тэргүүлэх чиглэлийг баталсан билээ. Энэхүү хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд Монгол хүнийг хөгжүүлэн ажиллаж амьдрах аюулгүй таатай орчныг бүрдүүлнэ хэмээн тэргүүлэх чиглэлдээ заасан байна. Стратегийн хүрээнд эрүүл мэндийг хамгаалах, хүн амаа өсгөх, амьдрах аюулгүй таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах

- Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн орчны шинэчлэлийг гүнзгийрүүлж, төрийн зохицуулалттай эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлнэ.
- Хүний эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Хүн амд нотолгоонд тулгуурласан эрүүл мэндийн чанартай, үр дүнтэй тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлснээр хүн амын тогтвортой өсөлтийг дэмжин, насжилтыг уртасгана.
- Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх, эрүүл мэндийн даатгалыг боловсронгуй болгож, иргэдийг жилд нэг удаа эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.
- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг тогтвортой хөгжүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагыг дээшлүүлнэ.
- Эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулна.
- Мэдээллийн дэвшилтэт технологийг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлж, цахим эрүүл мэндийг хөгжүүлнэ.
- Эрүүл мэндийн салбарт төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ.
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, удирдамж, шалгуур үзүүлэлтийг оновчтой болгох Монгол Улсын хүн амыг аюулгүй, чанарын баталгаатай эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслээр жигд, хүртээмжтэй хангана.
- Хүн амын дунд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, улмаар зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулахад чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгааг чанаржуулна.
- Олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах замаар



эрүүл мэндийг дэмжих орчинг бий болгоно.

- Сум, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай багцыг шинэчлэх, анхан шатны эмнэлгийн тусламж үзүүлэх байгууллагуудад хуваарилах төсвийн хэмжээг нэмэгдүүлнэ.

- Эрүүл мэндийн салбарын санхүүгийн болон нөөцийн ашиглалтын үр дүнг сайжруулж, санхүүжилтийг тогтмол нэмэгдүүлнэ.

- Эхийн болон нялхасын эндэгдэл, халдварт өвчлөлийг бууруулах зорилгоор Улаанбаатар хотод төрөх эмнэлгийг шинээр, аймаг орон нутагт нийлбэр дүнгээрээ 410 ор бүхий 9 төрөх эмнэлэг, 10 халдвартын эмнэлгийг тус тус барьж байгуулна.

- Орон нутагт сумын 71 эмнэлэг, сум дундын 6 эмнэлэг, бүсийн оношлогооны 6 төвийг байгуулна.


- Цахим эмнэлэг, зайн оношилгоог нэвтрүүлэх сургалт судалгаа, оношлогооны төв, халдварт өвчин судлалын үндэсний төвийн лаборатори, цус сэлбэлт судлалын үндэсний төв, эмгэг судлалын үндэсний төв, геронтологийн төв, түлэнхийн төвийг шинээр байгуулах, аймаг орон нутагт оношлогоо эмчилгээний төвүүдийг шинээр барьж ашиглалтад оруулна.

## **БҮЛЭГ II. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД**




**БҮЛЭГ II. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД****Жирэмсний хяналт**

Төрөхийн өмнө жирэмсэн эхчүүдэд үзүүлж буй үйлчилгээ нь тэдний эрүүл мэнд төдийгүй нялхсын эрүүл мэндэд маш чухал нөлөө үзүүлдэг. Мөн үр хөврөлийн өсөлт, хөгжил, эхийн эрүүл мэнд хоорондоо маш нарийн хамааралтай байдаг тул жирэмсэн үед мэргэжлийн эмчийн хяналтад хамрагдаж зохих заавар, зөвлөмж, үйлчилгээг авах нь чухал юм. 2012 оны эхний хагас жилийн байдлаар жирэмсний хяналтанд шинээр 40690 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 87.3 хувь нь эхний 3 сартайд, 11.5 хувь нь 4-6 сартайд, 1.2 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтанд орсон байна. Жирэмсний эрт үеийн хяналтын хувь өнгөрсөн оны мөн үеэс 3.3 пунктээр

**Зураг 1. Жирэмсний эрт хяналтын хувь, /2011-2012 оны хагас жилийн байдлаар/**

Шинээр хяналтанд орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 97.2 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсанаас 5.3 хувь нь цус багадалттай байна.

## Зураг 2. Цус багадалтай жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, /2012 оны хагас жилийн байдлаар/



Хяналтанд байгаа жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээнд 43538, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 42811, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 40772, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 37989 жирэмсэн эхчүүд хамрагдсан байна.

Бэлгийн замаар дамжих халдварын шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээний 1.9 хувь, заг хүйтэн илрүүлэх шинжилгээний 0.9 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээний 2.0 хувь нь эерэг үзүүлэлттэй гарсан байна.


## Хүснэгт 1. Жирэмсэн эмэгтэйчүүдийн шинжилгээнд хамрагдалт, /2012 оны хагас жилийн байдлаар/

| Аймгууд |                    | Трихомониаз илрүүлэх шинжилгээнд хамрагдсан | Үүнээс эерэг | Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд хамрагдсан | Үүнээс эерэг | Тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамрагдсан | Үүнээс эерэг |
|---------|--------------------|---------------------------------------------|--------------|--------------------------------------------|--------------|----------------------------------------|--------------|
| А       | Б                  | 1                                           | 2            | 3                                          | 4            | 5                                      | 6            |
| 1       | Архангай           | 1088                                        | 25           | 991                                        | 7            | 1271                                   | 14           |
| 2       | Баян-Өлгий         | 999                                         | 5            | 999                                        | 16           | 999                                    | 3            |
| 3       | Баянхонгор         | 873                                         | 97           | 884                                        | 27           | 1022                                   | 12           |
| 4       | Булган             | 884                                         | 62           | 875                                        | 3            | 885                                    | 13           |
| 5       | Говь-Алтай         | 590                                         | 0            | 593                                        | 7            | 627                                    | 9            |
| 6       | Говьсүмбэр         | 109                                         | 0            | 109                                        | 2            | 450                                    | 6            |
| 7       | Дархан-Уул         | 981                                         | 17           | 907                                        | 9            | 1708                                   | 22           |
| 8       | Дорноговь          | 1104                                        | 34           | 1104                                       | 7            | 829                                    | 21           |
| 9       | Дорнод             | 652                                         | 30           | 532                                        | 15           | 880                                    | 25           |
| 10      | Дундговь           | 359                                         | 5            | 350                                        | 3            | 361                                    | 4            |
| 11      | Завхан             | 512                                         | 1            | 504                                        | 1            | 576                                    | 5            |
| 12      | Орхон              | 1041                                        | 27           | 1041                                       | 1            | 1041                                   | 36           |
| 13      | Өвөрхангай         | 1080                                        | 1            | 1084                                       | 5            | 1090                                   | 1            |
| 14      | Өмнөговь           | 810                                         | 13           | 801                                        | 0            | 960                                    | 6            |
| 15      | Сүхбаатар          | 657                                         | 49           | 657                                        | 7            | 719                                    | 4            |
| 16      | Сэлэнгэ            | 1303                                        | 13           | 1281                                       | 24           | 1576                                   | 14           |
| 17      | Төв                | 1040                                        | 16           | 1018                                       | 3            | 1186                                   | 17           |
| 18      | Увс                | 536                                         | 10           | 544                                        | 2            | 1065                                   | 5            |
| 19      | Ховд               | 1275                                        | 6            | 929                                        | 5            | 960                                    | 1            |
| 20      | Хөвсгөл            | 1257                                        | 23           | 1259                                       | 27           | 1362                                   | 29           |
| 21      | Хэнтий             | 650                                         | 5            | 624                                        | 4            | 855                                    | 11           |
| 22      | <b>Аймгийн дүн</b> | <b>17880</b>                                | <b>439</b>   | <b>17166</b>                               | <b>175</b>   | <b>20442</b>                           | <b>258</b>   |
| 23      | Улаанбаатар        | 25658                                       | 388          | 25645                                      | 241          | 20330                                  | 563          |
| 24      | <b>Улсын дүн</b>   | <b>43538</b>                                | <b>827</b>   | <b>42811</b>                               | <b>416</b>   | <b>40772</b>                           | <b>821</b>   |

**Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ**


2012 оны эхний хагас жилийн байдлаар нийт 35945 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үеэс 6.7 /2251/ хувиар нэмэгдсэн байна. Төрөлт Архангай, Булган, Дорнод, Сэлэнгэ аймагт буурч бусад аймагт болон УБ хотод нэмэгджээ.

Нийт төрөлтийн 0.3 хувь нь гэрийн төрөлт байгаа ба гэрийн төрөлтийн 64.7 хувь нь

**Зураг 3. Төрсөн эхчүүд насны ангиллаар, 2012 оны хагас жилийн байдлаар**


Нийт төрсөн эхчүүдийг нийгмийн байдлаар нь авч үзэхэд: ажилчин 9.6, албан хаагч 19.9, оюутан 12.4, ажилгүй 48.8, малчин 9.3 хувийг тус тус эзэлж байна. Нийт төрөлтийн 94.5 хувийг эх барих, эмэгтэйчүүдийн эмч, 2.4 хувийг их эмч, 3.0 хувийг эх баригч бага эмч, 0.1 хувийг мэргэжлийн бус хүн удирдан төрүүлсэн байна.

Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод ирж амаржиж буй эхчүүдийн дийлэнх буюу 49.2 хувийг төвийн бүсээс, 13.4 хувь нь зүүн, 26.8 хувь нь хангай, говийн бүс, 10.6 хувь нь баруун бүсээс ирж төрсөн байна.

**Зураг 4. Улаанбаатарт хөдөө, орон нутгаас амаржсан эхчүүдийн тоо, 2012 оны хагас жилийн байдлаар**

Нийт төрсөн эхчүүдийн 22 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн байна.

**Зураг 5. Мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн эхийн эзлэх хувь, /2012 оны хагас жилийн байдлаар/**



Төрсөн эхчүүдийн 27.2 хувь жирэмсэн үеийн хүндрэл 36.4 хувь нь төрөх үеийн хүндрэлээр, 1.2 хувь нь төрсний дараах үеийн хүндрэлээр оношлогдож эмчлэгдсэн байна.

2012 оны эхний хагас жилийн байдлаар 3470 үр хөндөлт бүртгэгдсэн бөгөөд 1000 амьд төрөлтөд 96.5 ногдож байна. Нийт үр хөндөлтийн 77.5 хувь нь Улаанбаатар хотод, 22.5 хувь нь хөдөө орон нутагт хийгдсэн байна. Төрөх насны 1000 эмэгтэйд 4 үр хөндөлт ногдож байна.

**Төрөлт, төрөх үед үзүүлсэн эмнэлгийн тусламж (Аймгаар),  
2012 оны хагас жилийн байдлаар**


| №  | Аймаг хотын нэр       | Төрөлтийн эзлэх хувь          |                 |                           |                |                         |            | Эмнэлгийн тусламжгүй төрсөн төрөлтийн эзлэх | 20-оос доош насны төрөлтийн эзлэх хувь | 35-нас дээш насны төрөлтийн эзлэх хувь | 2500 граммаас доош жинтэй төрсөн хүүхдийн эзлэх хувь |
|----|-----------------------|-------------------------------|-----------------|---------------------------|----------------|-------------------------|------------|---------------------------------------------|----------------------------------------|----------------------------------------|------------------------------------------------------|
|    |                       | Аймаг, хотын нэгдсэн эмнэлэгт | Хувийн эмнэлэгт | Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг | Сумын эмнэлэгт | Их эмчийн ортой салбарт | Гэртээ     |                                             |                                        |                                        |                                                      |
|    | А                     | 1                             | 2               | 3                         | 4              | 5                       | 6          | 7                                           | 8                                      | 9                                      | 10                                                   |
| 1  | Архангай              | 72.0                          | 0.0             | 0.0                       | 27.8           | 0.2                     | 0.1        | 0.0                                         | 4.8                                    | 7.8                                    | 4.7                                                  |
| 2  | Баян-Өлгий            | 70.2                          | 0.0             | 0.0                       | 29.8           | 0.0                     | 0.1        | 0.0                                         | 1.0                                    | 9.9                                    | 3.5                                                  |
| 3  | Баянхонгор            | 81.6                          | 0.0             | 0.0                       | 18.0           | 0.4                     | 0.0        | 0.0                                         | 7.1                                    | 7.1                                    | 2.7                                                  |
| 4  | Булган                | 72.7                          | 0.0             | 0.0                       | 27.3           | 0.0                     | 0.4        | 0.2                                         | 6.8                                    | 9.4                                    | 2.2                                                  |
| 5  | Говь-Алтай            | 73.7                          | 0.0             | 10.0                      | 15.8           | 0.6                     | 0.3        | 0.3                                         | 3.4                                    | 7.0                                    | 4.0                                                  |
| 6  | Говьсүмбэр            | 100.0                         | 0.0             | 0.0                       | 0.0            | 0.0                     | 0.0        | 0.0                                         | 8.5                                    | 10.4                                   | 0.5                                                  |
| 7  | Дархан-Уул            | 96.4                          | 0.0             | 0.0                       | 3.6            | 0.0                     | 0.3        | 0.1                                         | 6.3                                    | 11.4                                   | 2.4                                                  |
| 8  | Дорноговь             | 79.5                          | 0.0             | 18.6                      | 1.9            | 0.0                     | 0.0        | 0.0                                         | 9.8                                    | 7.6                                    | 3.2                                                  |
| 9  | Дорнод                | 96.5                          | 0.0             | 0.0                       | 3.5            | 0.0                     | 0.2        | 0.0                                         | 5.0                                    | 9.4                                    | 4.2                                                  |
| 10 | Дундговь              | 84.1                          | 0.0             | 0.0                       | 15.9           | 0.0                     | 0.3        | 0.0                                         | 6.9                                    | 7.7                                    | 3.3                                                  |
| 11 | Завхан                | 54.9                          | 0.0             | 21.8                      | 23.3           | 0.0                     | 0.3        | 0.0                                         | 3.7                                    | 8.5                                    | 1.5                                                  |
| 12 | Орхон                 | 99.5                          | 0.0             | 0.0                       | 0.5            | 0.0                     | 0.2        | 0.1                                         | 5.6                                    | 10.6                                   | 3.8                                                  |
| 13 | Өвөрхангай            | 65.5                          | 1.4             | 10.9                      | 22.2           | 0.1                     | 0.2        | 0.0                                         | 8.4                                    | 7.8                                    | 4.4                                                  |
| 14 | Өмнөговь              | 81.2                          | 0.0             | 0.0                       | 18.8           | 0.0                     | 0.2        | 0.0                                         | 10.3                                   | 7.3                                    | 6.1                                                  |
| 15 | Сүхбаатар             | 92.1                          | 0.0             | 0.0                       | 7.8            | 0.0                     | 0.3        | 0.0                                         | 8.6                                    | 7.8                                    | 3.3                                                  |
| 16 | Сэлэнгэ               | 56.8                          | 0.0             | 30.4                      | 12.8           | 0.0                     | 0.1        | 0.0                                         | 5.9                                    | 8.2                                    | 4.0                                                  |
| 17 | Төв                   | 65.1                          | 0.0             | 0.0                       | 34.9           | 0.0                     | 0.6        | 0.2                                         | 7.9                                    | 10.6                                   | 4.3                                                  |
| 18 | Увс                   | 70.2                          | 0.0             | 0.0                       | 29.8           | 0.0                     | 0.6        | 0.3                                         | 3.3                                    | 10.5                                   | 4.5                                                  |
| 19 | Ховд                  | 76.7                          | 0.0             | 8.2                       | 15.1           | 0.0                     | 0.0        | 0.0                                         | 2.9                                    | 10.9                                   | 4.1                                                  |
| 20 | Хөвсгөл               | 68.6                          | 0.0             | 0.0                       | 31.4           | 0.0                     | 0.1        | 0.0                                         | 7.8                                    | 7.3                                    | 2.9                                                  |
| 21 | Хэнтий                | 75.2                          | 0.0             | 14.0                      | 10.6           | 0.3                     | 0.1        | 0.0                                         | 11.8                                   | 6.3                                    | 3.1                                                  |
| 22 | <b>Аймгийн дундаж</b> | <b>77.1</b>                   | <b>0.1</b>      | <b>5.3</b>                | <b>17.4</b>    | <b>0.1</b>              | <b>0.2</b> | <b>0.0</b>                                  | <b>6.1</b>                             | <b>8.8</b>                             | <b>3.5</b>                                           |
| 23 | Улаанбаатар           | 96.9                          | 3.1             | 0.0                       | 0.0            | 0.0                     | 0.4        | 0.2                                         | 5.4                                    | 10.8                                   | 4.5                                                  |
| 24 | <b>Улсын дундаж</b>   | <b>86.7</b>                   | <b>1.6</b>      | <b>2.7</b>                | <b>9.0</b>     | <b>0.0</b>              | <b>0.3</b> | <b>0.1</b>                                  | <b>5.8</b>                             | <b>9.8</b>                             | <b>4.0</b>                                           |

## Хүүхдийн эрүүл мэнд

Улсын хэмжээнд 2012 оны эхний хагас жилийн байдлаар нийт 36129 хүүхэд төрсөн байна. Амьд төрсөн хүүхдийн 51.1 хувь нь эрэгтэй, 48.9 хувь нь эмэгтэй байна. Өнгөрсөн оны мөн үеэс 2270 хүүхдээр буюу 6.7 хувиар нэмэгджээ. Амьд төрсөн хүүхдийн 4.0/1438/ хувь нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төржээ. Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 92.2 байна.


Эхний хагас жилийн байдлаар 1000 нийт төрөлтөд ногдох амьгүй төрөлт 5.8 байна. Баян-Өлгий /15.0/, Ховд /12.8/, Завхан /10.5/, Хэнтий /9.0/, Дорнод /7.3/, Увс /8.8/, Говь-Алтай /7.1/, Улаанбаатар /6.2/ байгаа нь улс болон аймгийн дундажаас өндөр үзүүлэлттэй байна.

**Зураг 6. Амьгүй төрөлтийн түвшин, 1000 төрөлтөд /2012 оны хагас жилийн байдлаар/**



Тухайн сард улсын хэмжээнд 5 хүртэлх насны нийт 177527 хүүхэд жинлэсэн

**Зураг 7. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлтийн хяналт, /2012 оны хагас жилийн байдлаар/**






**Эхийн эндэгдэл**

2012 оны эхний хагас жилийн байдлаар эхийн эндэгдлийн 18 тохиолдол бүртгэгдэж 100.000 амьд төрөлтөд 49.8 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.4

**Хүснэгт 2. Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд 2008-2012 оны хагас жилийн байдлаар**

| Байршил        | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 |
|----------------|------|------|------|------|------|
| Улсын дундаж   | 32.6 | 70.5 | 44.7 | 50.2 | 49.8 |
| УБ хот         | 30.8 | 54.2 | 46.0 | 43.8 | 39.8 |
| Аймгийн дундаж | 33.9 | 82.8 | 43.6 | 55.9 | 59.3 |

Эхийн эндэгдлийн нийт тохиолдлыг шалтгаанаар нь авч үзэхэд жирэмсэн үеийн хүндрэлээр-4, төрөх үеийн хүндрэлээр-2, төрсний дараах үеийн хүндрэлээр -6,

**Зураг 8. Эхийн эндэгдэл насны ангилал, байршлаар, 2012 оны хагас жилийн**

Нийгмийн байдлаар авч үзэхэд эндсэн эхчүүд нь ажилгүй-8, нийгмийн ажилтан-5, малчин-4, оюутан-1 байна.

Эхийн эндэгдлийн 7 (38.8%) тохиолдол Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд 100000 амьд төрөлтөд 39.8, Баян-Өлгий 1 (80.3), Баянхонгор 2 (183.5), Дархан-Уул 1(78.4), Дорнод 1(104.4), Завхан 2 (264.2), Өвөрхангай 1 (80.1), Сүхбаатар 1(156.7), Сэлэнгэ 1(107.5), Төв 1 (187,6) ногдож байна.

**Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, /1000 амьд төрөлтөд/**

Улсын хэмжээнд 2012 оны эхний хагас жилийн байдлаар нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 590 тохиолдол бүртгэгдэж амьд төрсөн 1000 хүүхдэд 16.3 ногдож байна. Өнгөрсөн оны мөн үеэс 1000 амьд төрөлт тутамд ногдох хүүхдийн эндэгдэл 1.6-өөр


**Хүснэгт 3. Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд /2008-2012 оны хагас жилийн байдлаар/**

| Байршил        | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 |
|----------------|------|------|------|------|------|
| Улсын дундаж   | 21.1 | 20.6 | 21.2 | 17.9 | 16.3 |
| УБ хот         | 18.3 | 18.8 | 16.0 | 15.3 | 13   |
| Аймгийн дундаж | 23.2 | 22.0 | 25.4 | 20.3 | 19.5 |


Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 51.5 хувь нь 0-6 хоногтойдоо буюу нярайн эрт үедээ, 12.7 хувь нь 7-28 хоногтойдоо буюу нярайн хожуу үедээ, 35.8 хувь нь 29 ба түүнээс дээш хоногтойд эндсэн байна.

Нярайн эндэгдэл 1000 амьд төрсөн хүүхдэд 10.3, перинаталь эндэгдэл нийт төрөлтөд 14.3 байна. Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 58.7 хувь нь эрэгтэй, 41.3 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

1000 амьд төрөлтөд ногдох нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Хөвсгөл 35.5, Баян-Өлгий 26.5, Сүхбаатар 26.6, Ховд 20.7, Өвөрхангай 24.8, Булган 21.7, Говь-Алтай 19.9, Завхан 23.8, байгаа нь улс аймгийн дунджаас өндөр байна.

**Зураг 9. Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд /2012 оны хагас жилийн байдлаар/**

Перинаталь эндэгдлийн түвшин баруун бүсийн аймгууд болох Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан зэрэг аймгуудад улсын дунджаас 2.3-12.8 промилль-оор өндөр байна. Түүнчлэн Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий аймгуудад улсын дунджаас өндөр байна.

**Зураг 10. Перинаталь эндэгдэл, 1000 нийт төрөлтөд /2012 оны хагас жилийн байдлаар/**

2012 оны эхний хагас жилийн байдлаар тав хүртэлх насандаа 711 хүүхэд эндсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 23 тохиолдол, амьд төрсөн 1000 хүүхэд тутамд 2.0 хүүхдээр буурсан байна. /2011 оны эхний хагас жилийн байдлаар амьд төрсөн 1000 хүүхдэд 21.7/. Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 56.5 хувь нь эрэгтэй, 43.4 хувь нь

**Хүснэгт 4. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд /2008-2012 оны хагас жилийн байдлаар/**


| Байршил        | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 |
|----------------|------|------|------|------|------|
| Улсын дундаж   | 25.4 | 23.6 | 26.8 | 21.7 | 19.7 |
| УБ хот         | 22.3 | 21.3 | 20.5 | 18.2 | 16.1 |
| Аймгийн дундаж | 27.8 | 25.3 | 32.0 | 24.8 | 23.1 |

Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 56.5 хувь нь эрэгтэй, 43.5 хувь нь эмэгтэй

**Хүснэгт 5. Нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, 1000 амьд төрөлтөд, /2012 оны хагас жилийн байдлаар/**

| Өвчний нэршлээр                              | 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл |                   | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл |                   |
|----------------------------------------------|-----------------------------------|-------------------|-----------------------------------|-------------------|
|                                              | Хот                               | Хөдөө             | Хот                               | Хөдөө             |
| Амьсгалын тогтолцооны өвчин                  | 5.2                               | 28.0              | 9.5                               | 28.0              |
| Перинаталь үед үүссэн зарим эмгэг            | 65.8                              | 46.2              | 54.0                              | 38.3              |
| Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг | 16.8                              | 8.3               | 15.6                              | 7.5               |
| Нас баралтын гадны шалтгаан                  | 2.3                               | 7.7               | 9.5                               | 13.4              |
| Бусад эрхтэн тогтолцооны өвчин               | 9.9                               | 9.8               | 11.4                              | 12.8              |
| <b>Бүгд</b>                                  | <b>184/37.4%/</b>                 | <b>308/62.6%/</b> | <b>227/38.4%/</b>                 | <b>364/61.6%/</b> |

Зураг 11. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд /2012 оны хагас жилийн байдлаар/



Хүснэгт 6. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, хувиар /2012 оны хагас жилийн байдлаар/

| Өвчний бүлэг ӨОУА-10                              | 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл |              |             |              |            |              | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл |              |             |              |            |              |
|---------------------------------------------------|-----------------------------------|--------------|-------------|--------------|------------|--------------|-----------------------------------|--------------|-------------|--------------|------------|--------------|
|                                                   | Аймгийн дүн                       |              | Улаанбаатар |              | Улсын дүн  |              | Аймгийн дүн                       |              | Улаанбаатар |              | Улсын дүн  |              |
|                                                   | Бодит тоо                         | Хувь         | Бодит тоо   | Хувь         | Бодит тоо  | Хувь         | Бодит тоо                         | Хувь         | Бодит тоо   | Хувь         | Бодит тоо  | Хувь         |
| Төрөх тойрны (перинаталь) үед үүсэх өйг           | 169                               | 46.7         | 140         | 61.4         | 309        | 52.4         | 169                               | 39.5         | 140         | 49.5         | 309        | 43.5         |
| Амьсгалын тогтолцооны өвчин                       | 99                                | 27.3         | 23          | 10.1         | 122        | 20.7         | 111                               | 25.9         | 35          | 12.4         | 146        | 20.5         |
| Төрөлхийн гажиг, хэв гажил, өнгөт цогцын гажуудал | 31                                | 8.6          | 32          | 14.0         | 63         | 10.7         | 36                                | 8.4          | 37          | 13.1         | 73         | 10.3         |
| Өвчлөл ба нас баралтын гаднын шалтгаан            | 28                                | 7.7          | 7           | 3.1          | 35         | 5.9          | 57                                | 13.3         | 35          | 12.4         | 92         | 12.9         |
| Хоол боловсруулах тогтолцооны өвчин               | 8                                 | 2.2          | 4           | 1.8          | 12         | 2.0          | 11                                | 2.6          | 6           | 2.1          | 17         | 2.4          |
| Мэдрэлийн тогтолцооны өвчин                       | 16                                | 4.4          | 7           | 3.1          | 23         | 3.9          | 22                                | 5.1          | 10          | 3.5          | 32         | 4.5          |
| Халдварт ба шимэгчит зарим өвчин                  | 4                                 | 1.1          | 6           | 2.6          | 10         | 1.7          | 8                                 | 1.9          | 7           | 2.5          | 15         | 2.1          |
| Бусад                                             | 7                                 | 1.9          | 9           | 3.9          | 16         | 2.7          | 14                                | 3.3          | 13          | 4.6          | 27         | 3.8          |
| <b>Бүгд</b>                                       | <b>362</b>                        | <b>100.0</b> | <b>228</b>  | <b>100.0</b> | <b>590</b> | <b>100.0</b> | <b>428</b>                        | <b>100.0</b> | <b>283</b>  | <b>100.0</b> | <b>711</b> | <b>100.0</b> |

## Нялхсын эндэгдэл /2012 оны хагас жилийн байдлаар/

| №  | Аймаг хотын нэр       | Перинаталь нас баралт (амьд амьгүй төрсөн 1000 хүүхдэд) | Нярайн нас баралт (амьд төрсөн 1000 хүүхдэд) | Нярайн эрт үеийн нас баралт (амьд төрсөн 1000 хүүхдэд) | Нярайн хожуу үеийн нас баралт (амьд төрсөн 1000 хүүхдэд ) |
|----|-----------------------|---------------------------------------------------------|----------------------------------------------|--------------------------------------------------------|-----------------------------------------------------------|
| 1  | Архангай              | 10.9                                                    | 11.9                                         | 9.0                                                    | 3.0                                                       |
| 2  | Баян-Өлгий            | 23.7                                                    | 13.6                                         | 8.8                                                    | 4.8                                                       |
| 3  | Баянхонгор            | 10.1                                                    | 7.3                                          | 7.3                                                    | 0.0                                                       |
| 4  | Булган                | 13.0                                                    | 13.0                                         | 8.7                                                    | 4.3                                                       |
| 5  | Говь-Алтай            | 12.7                                                    | 9.9                                          | 5.7                                                    | 4.3                                                       |
| 6  | Говьсүмбэр            | 5.0                                                     | 0.0                                          | 0.0                                                    | 0.0                                                       |
| 7  | Дархан-Уул            | 3.1                                                     | 5.5                                          | 2.4                                                    | 3.1                                                       |
| 8  | Дорноговь             | 5.7                                                     | 8.6                                          | 4.3                                                    | 4.3                                                       |
| 9  | Дорнод                | 13.5                                                    | 8.4                                          | 6.3                                                    | 2.1                                                       |
| 10 | Дундговь              | 12.6                                                    | 10.1                                         | 10.1                                                   | 0.0                                                       |
| 11 | Завхан                | 27.5                                                    | 17.2                                         | 17.2                                                   | 0.0                                                       |
| 12 | Орхон                 | 12.0                                                    | 10.4                                         | 9.6                                                    | 0.8                                                       |
| 13 | Өвөрхангай            | 21.6                                                    | 21.6                                         | 18.4                                                   | 3.2                                                       |
| 14 | Өмнөговь              | 17.2                                                    | 15.7                                         | 14.1                                                   | 1.6                                                       |
| 15 | Сүхбаатар             | 14.1                                                    | 14.1                                         | 11.0                                                   | 3.1                                                       |
| 16 | Сэлэнгэ               | 7.5                                                     | 4.3                                          | 4.3                                                    | 0.0                                                       |
| 17 | Төв                   | 7.5                                                     | 9.4                                          | 7.5                                                    | 1.9                                                       |
| 18 | Увс                   | 16.7                                                    | 9.9                                          | 7.9                                                    | 2.0                                                       |
| 19 | Ховд                  | 20.4                                                    | 8.6                                          | 7.8                                                    | 0.9                                                       |
| 20 | Хөвсгөл               | 20.2                                                    | 17.1                                         | 15.9                                                   | 1.3                                                       |
| 21 | Хэнтий                | 16.8                                                    | 9.1                                          | 7.8                                                    | 1.3                                                       |
| 22 | <b>Аймгийн дундаж</b> | <b>14.7</b>                                             | <b>11.3</b>                                  | <b>9.3</b>                                             | <b>2.0</b>                                                |
| 23 | Улаанбаатар           | 13.6                                                    | 9.6                                          | 7.5                                                    | 2.1                                                       |
| 24 | <b>Улсын дундаж</b>   | <b>14.2</b>                                             | <b>10.5</b>                                  | <b>8.4</b>                                             | <b>2.1</b>                                                |


### **БҮЛЭГ III. АМБУЛАТОРИ СТАЦИОНАРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ**



**БҮЛЭГ 3. АМБУЛАТОРИ СТАЦИОНАРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ**


Улсын хэмжээнд 2012 оны эхний хагас жилд амбулаторт нийт 8558554 үзлэг хийгдсний 38.8 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 39.7 хувийг өвчний учир амбулаторт, 8.4 хувийг идэвхитэй хяналт, 13.2 хувийг гэрийн идэвхитэй болон дуудлагын үзлэг эзэлж байна. Амбулатороор хийгдсэн үзлэгийн 16.9 хувийг сумын эмчийн үзлэг, 28.8 хувийг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн эмчийн үзлэг, 35.5 хувийг өрхийн эмчийн үзлэг эзэлж байна.

**Зураг 12. Амбулаторийн үзлэгийн төрөл, хувиар /2011-2012 оны хагас жилийн байдлаар/**



Амбулаторийн үзлэгээр халдварт бус өвчлөлийн 603536 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеийнхээс өвчлөл 8.1 хувиар нэмэгджээ. Бүртгэгдсэн халдварт бус өвчлөлийн 53984 тохиолдол буюу 8.9 хувь нь осол гэмтлийн өвчлөл эзэлж байна. Улсын хэмжээнд 2012 оны эхний хагас жилийн байдлаар эмнэлэгт 371616 эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлж 2943687 ор хоног ашигласан бөгөөд дундаж ор хоног 7.9 байна. Улсын хэмжээнд нийт 40112 эмчлүүлэгчид мэс заслын хагалгаа хийгдсэн бөгөөд Улаанбаатар хотын эмнэлгүүдэд 65.2 хувь нь хийгджээ.

**Зураг 13. Мэс заслын хагалгаа бодит тоогоор /2012 оны хагас жилийн байдлаар/**



**Хүснэгт 7. Зонхилон хийгдсэн мэс заслын хагалгаа төрлөөр /2012 оны хагас жилийн байдлаар/****7 а. Аймаг**

| №  | Мэс заслын нэр                   | Мэс засал<br>хийлгэсэн х<br>тоо | Нийт мэс заслын<br>хагалгаанд<br>эзлэх хувь |
|----|----------------------------------|---------------------------------|---------------------------------------------|
| 1  | Цочмог мухар олгойн мэс засал    | 4024                            | 28.9                                        |
| 2  | Эмэгтэйнүүдийн бусад мэс засал   | 942                             | 6.8                                         |
| 3  | Цөсний замын мэс засал           | 639                             | 4.6                                         |
| 4  | Үе мөчний бусад мэс засал        | 620                             | 4.4                                         |
| 5  | Хамар хоолойн мэс засал          | 503                             | 3.6                                         |
| 6  | Эр бэлэг эрхтний бусад мэс засал | 324                             | 2.3                                         |
| 7  | Нүдний бусад мэс засал           | 311                             | 2.2                                         |
| 8  | Бусад                            | 303                             | 2.2                                         |
| 9  | Ивэрхийн мэс засал               | 301                             | 2.2                                         |
